



“УЛИАСТАЙ ВАН АУДИТ” ХХК

## АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

“ХАРХОРИН” ХК  
(Монгол улсад бүртгэлтэй яж ахуй нэгж)

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр  
тасалбар болгосон санхүүгийн тайлан

УЛААНБААТАР ХОТ  
2020 ОН

## АГУУЛГА

### Хуудас

БАЙГУУЛЛАГЫН МЭДЭЭЛЭЛ	1
ХАРААТ БУС АУДИТОРЫН ДУГНЭЛТ	2
2019 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	
АУДИТЛАСАН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН	3
АУДИТЛАСАН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН	4
АУДИТЛАСАН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН	5
АУДИТЛАСАН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН	6
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	7-17
МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ	18-21

**“ХАРХОРИН” ХК**

**БАЙГУУЛЛАГЫН МЭДЭЭЛЭЛ**

ЗАХИРАЛ:

Р.САРАНЦЭЦЭГ

НЯГТЛАН БОДОГЧ :

Д.ДАШМАА

КОМПАНИЙ РЕГИСТР :

2015471

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ:

Жимс, жимсгэний худалдаа

БАЙГУУЛЛАГЫН ХАЯГ

Өвөрхангай аймаг, Хар хорин сум

Улаанбаатар, Монгол улс  
Утас: (+976 9595 3170, 9418 6636)

И-мэйл хаяг: [assistant.kh.kh@gmail.com](mailto:assistant.kh.kh@gmail.com)

АУДИТЫН КОМПАНИ:

Нягтлан бодох бүртгэл хяналтын  
итгэмжлэгдсэн байгууллага-  
УЛИАСТАЙ ВАН АУДИТ ХХК  
Утас: 76007405, 9909 7405  
И-мэйл хаяг: [uliastaivanaudit@ubaudit.mn](mailto:uliastaivanaudit@ubaudit.mn)  
Вэб хаяг: [www.ubaudit.mn](http://www.ubaudit.mn)



## “УЛИАСТАЙ ВАН АУДИТ” ХХК

Аудит, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн зөвлөгөө, бүртгэлийн программ, сургалтын итгэмжлэгдсэн байгууллага

20<sup>00</sup> оны 03 дугаар сарын 20-ны өдөр

Дугаар 100/  
0000

### ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

#### “ХАРХОРИН” ХК-ийн УДИРДЛАГАД

Бид “Хархорин” ХК-ийн (цаашид “Компани” гэх) 2019 оны 12 дугаар сарын 31-ны санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр тасалбар болгосон жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан эдгээр санхүүгийн тайлантай холбоотой нэмэлт тодруулга болон нягтлан бодох бүртгэлийн бодлогуудал аудит хийлээ.

#### Санхүүгийн тайлантай холбоотой удирдлагын хариуцлага

Эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлантай олон улсын стандартын дагуу бэлтгэж, толилуулах нь компанийн удирдлагын үүрэг болно. Энэхүү үүрэг хариуцлагад санхүүгийн тайлангуудыг залилан юмуу алдаанаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийлэгүйгээр бэлтгэж, шударгаар толилуулахтай холбоотой дотоод хяналтын системийг зохиож, хэрэгжүүлэн, түүнийгээ туштай ажиллуулах, нягтлан бодох бүртгэлийн тохиромжтой бодлогуудыг сонгож, хэрэглэх, нөхцөл байдалд тохируулан нягтлан бодох бүртгэлийн тооцооллуудыг хийх зэрэг зүйлс багтана.

#### Аудиторын үүрэг хариуцлага

Бидний үүрэг хариуцлага бол гүйцэтгэсэн аудитдаа тулгуурлан эдгээр санхүүгийн тайлангуудад дүгнэлт гаргах явдал юм. Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэдэг. Эдгээр стандартууд нь ёс зүйн шаардлагуудыг баримталж, санхүүгийн тайлангууд нь материаллаг зөрчилгүй илэрхийлэгдсэн эсэх талаар ул үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг биднээс шаарддаг. Аудитын үед санхүүгийн тайлангууд дахь дүн болон тодруулгын талаар аудитын нотолгоо олж авахад чиглэгдсэн горимуудыг гүйцэтгэсэн. Эдгээр горимуудыг аудиторын шийдэлд суурилан сонгосон бөгөөд үүнд, залилан юмуу алдаанаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллийн эрсдлийн тооцоолол багтдаг. Эдгээр эрсдлийн тооцоололыг хийхтэй холбоотойгоор аудитор компанийн дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд нь дүгнэлт өгөх зорилгоор бус харин тухайн нөхцөл байдалд тохирсон аудитын горимыг сонгож хэрэглэх зорилгоор компанийн санхүүгийн тайланг бэлтгэж, шударгаар толилуулахад зориулан хэрэглэж байгаа дотоод хяналтыг авч үздэг. Мөн санхүүгийн тайлagnalыг бүхэлд нь үнэлхээс гадна, удирдлагын зүгээс хийсэн томоохон тооцооллуудын үндэслэлтэй байдал, хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын тохиромжтой байдлыг үнэлэх ажлыг бидний аудит багтаасан. Бидний гүйцэтгэсэн аудит нь аудитын дүгнэлт хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоогоор хангагдсан гэж бид итгэж байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын олон улсын стандарт (АОУС)-ын дагуу хийсэн. Эдгээр стандартын дагуу хүлээх хариуцлагаа энэхүү тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх хариуцлага хэсэгт тайлбарласан. Нягтлан бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөл (НБЕЗОУС3)-өөс гаргасан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Аудитын тухай Монгол улсын хуулиар санхүүгийн тайлангийн аудитад тавигдах ёс зүйн шаардлагын дагуу Бид компаниас хараат бус бөгөөд хууль болон НБЕЗОУС3-өөс гаргасан дурмийн шаардлагын дагуу тавигддаг ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн. Бидний олж авсан аудитын нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэдэгт найдаж байна.

#### Хэрэглээний хязгаарлалт

Энэхүү тайлан нь Монгол улсын “Компанийн тухай хууль”-ийн 94 дүгээр зүйлд заасан хуулийн этгээд болох хувьцаа эзэмшигчийн хүсэлтийн дагуу зөвхөн компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулагдсан ба аливаа нэг өөр зорилго агуулаагүй болно. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд бусад этгээдийн өмнө үүрэг хариуцлага хүлэхгүй болно.

#### Бусад хууль тогтоомж, зохицуулалтын шаардлагын талаарх тайлан

Түүнчлэн, санхүүгийн тайлан бэлтгэхдээ Монгол улсад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн зарчмууд болон Сангийн сайдын баталсан нягтлан бодох бүртгэлийн журам, заавартай нийцэж байна

“УЛИАСТАЙ ВАН АУДИТ” ХХК

**“ХАРХОРИН” ХК**  
**АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**  
**2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрхү**

(мянган төгрөг)

		<b>2018.12.31</b>	<b>2019.12.31</b>
<b>Хөрөнгө</b>			
Мөнгө ба түүнтэй адилтгах зүйлс	4	1,897	1,382
Дансны авлага	5	903,269	540,692
Бусад авлага	6	268,650	54,439
Бусад санхүүгийн хөрөнгө	7	1,296,918	1,296,918
Бараа материал	8	425,494	391,668
Бусад эргэлтийн хөрөнгө	9	2,095,102	2,636,360
Үндсэн хөрөнгө	10	1,647,844	1,891,916
Биологийн хөрөнгө	11	1,082,788	1,082,788
<b>Нийт хөрөнгийн дүн</b>		<b>7,721,961</b>	<b>7,896,163</b>
<b>Өр төлбөр</b>			
Богино хугацаат өр төлбөр			
Дансны өглөг	12	6,089,839	6,718,914
Цалингийн өглөг	12	92,906	135,242
Татварын өр	12	11,558	22,405
НДШ-ийн өглөг	12	11,718	18,233
Богино хугацаат зээл	12	1,015,753	1,088,047
Хүүний өглөг	12	380,036	543,577
<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>		<b>7,601,811</b>	<b>8,526,418</b>
Урт хугацаат өр төлбөр			
Урт хугацаат зээл	13	673,380	70,000
<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>		<b>673,380</b>	<b>70,000</b>
Өр төлбөрийн нийт дүн		<b>8,275,191</b>	<b>8,596,418</b>
Эзэмшигчдийн өмч			
Өмч /хувийн/	14	836,220	836,220
Хуримтлагдсан ашиг алдагдал	15	(1,389,450)	(1,536,476)
Эзэмшигчдийн өмчийн дүн		<b>(553,230)</b>	<b>(700,255)</b>
<b>Өр төлбөр эзэмшигчдийн өмчийн дүн</b>		<b>7,721,961</b>	<b>7,896,163</b>

**“ХАРХОРИН” ХК**

**АУДИТЛАГДСАН ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН**

**2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн**

(мянган төгрөг)

		2018.12.31	2019.12.31
Борлуулалтын орлого	16	1,362,445	887,638
Борлуулалтын өртөг	17	1,336,367	866,851
<b>Нийт ашиг, (алдагдал)</b>		<b>26,079</b>	<b>20,786</b>
Бусад орлого	18	90,575	59,042
Ерөнхий ба удирдлагын зардал	19	178,915	182,667
Бусад зардал	18	48,669	44,186
<b>Татвар төлөхийн өмнөх ашиг, алдагдал</b>		<b>(110,930)</b>	<b>(147,026)</b>
Орлогын албан татварын зардал		-	-
<b>Татварын дараах ашиг, алдагдал</b>		<b>(110,930)</b>	<b>(147,026)</b>
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		-	-
<b>Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал</b>		<b>(110,930)</b>	<b>(147,026)</b>
<b>Цэвэр ашиг (алдагдал)</b>		<b>(110,930)</b>	<b>(147,026)</b>

**“ХАРХОРИН” ХК**

**АУДИТЛАГДСАН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

**2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн**

**(мянган төгрөг)**

	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	Өмчийн дүн
<b>2017 оны 12 дугаар сарын 31-ний улдэгдэл</b>	<b>836,220</b>		<b>(1,389,450)</b>	<b>(553,230)</b>
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
<b>Залруулсан улдэгдэл</b>	<b>836,220</b>		<b>(1,389,450)</b>	<b>(553,230)</b>
Бусад дэлгэрэнгүй орлого				-
Өмчид гарсан өөрчлөлт				-
Тайлангийн үеийн цэвэр ашиг (алдагдал)				-
Хуваарилсан ногдол ашиг				-
Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг				-
<b>2018 оны 12 дугаар сарын 31-ний улдэгдэл</b>	<b>836,220</b>		<b>(1,389,450)</b>	<b>(553,230)</b>
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
<b>Залруулсан улдэгдэл</b>	<b>836,220</b>		<b>(1,389,450)</b>	<b>(553,230)</b>
Бусад дэлгэрэнгүй орлого				-
Тайлангийн үеийн цэвэр ашиг (алдагдал)			<b>(147,026)</b>	<b>(147,026)</b>
Зарласан ногдол ашиг				-
Өмчид гарсан өөрчлөлт				-
<b>2019 оны 12 дугаар сарын 31-ний улдэгдэл</b>	<b>836,220</b>		<b>(1,536,476)</b>	<b>(700,255)</b>

**“ХАРХОРИН” ХК**  
**АУДИТЛАГДСАН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**  
**2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн**

(мянган төгрөг)

	<b>2018.12.31</b>	<b>2019.12.31</b>
<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>Мөнгөн орлогын дүн</b>	<b>2,750,270</b>	<b>1,937,147</b>
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	29,174	718,299
Бусад орлого	2,721,097	1,218,848
<b>Мөнгөн зарлагын дүн</b>	<b>2,750,451</b>	<b>1,937,662</b>
Ажилчдад төлсөн	313,318	199,386
НД-ийн байгууллагад төлсөн	123,973	88,698
Бараа материал худалдан авахад төлсөн	6,464	10,190
Ашиглалтын зардалд төлсөн мөнгө	13,152	9,995
Түвшн шатахуун, тээврийн хэлс, сэлбэг хэрэгсэд төлсөн мөнгө	50,362	91,523
Хүүний төлбөрт төлсөн мөнгө	183,154	155,244
Татварын байгууллагад төлсөн мөнгө	54,142	27,437
Бусад мөнгөн зарлага	2,005,887	1,355,189
<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(180)</b>	<b>(515)</b>
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>Мөнгөн орлогын дүн</b>	<b>-</b>	<b>-</b>
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
<b>Мөнгөн зарлагын дүн</b>	<b>-</b>	<b>-</b>
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
<b>Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>Мөнгөн орлогын дүн</b>	<b>-</b>	<b>-</b>
Зээл авсан, ерийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
<b>Мөнгөн зарлагын дүн</b>	<b>-</b>	<b>-</b>
Зээл, ерийн үнэт цаас төлбөрт төлсөн мөнгө	-	-
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	-
<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>-</b>	<b>-</b>
Валютын ханшийн зөрүү	-	-
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(180)	(515)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,077	1,897
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,897	1,382

## **“ХАРХОРИН” ХК**

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон  
жилийн санхүүгийн тайлангийн тодруулга

---

### **1. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ БА УЙЛ АЖИЛЛАГАА**

“Хархорин” ХК нь Монгол Улсын “Компанийн тухай” хууль болон бусад холбогдох хуулийн дагуу 1996 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр Жимс, жимсгэнэ худалдааны үйл ажиллагаа явуулах чиглэлээр үүсгэн байгуулагдсан.

### **2. САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ЗАРЧИМ**

#### **Нягтлан бodoх бүртгэлийн үндэс**

Энэхүү санхүүгийн тайланг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (цаашид СТОУС гэх), Олон улсын санхүүгийн тайлагналын Тайлбарын байнгын хорооноос баталсан тайлбар болон Монгол улсын зохих хууль, тогтоомжийн дагуу бэлтгэсэн.

#### **Үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг бэлтгэсэн валют**

Компанийн үйл ажиллагааны валют нь Монгол Улсын үндэсний валют төгрөг юм. Хавсаргасан санхүүгийн тайланг нэгжийн оронг төгрөгөөр бэлтгэсэн.

#### **Үнэлгээ**

Санхүүгийн тайланг түүхэн өргтийн зарчмаар бэлтгэсэн.

#### **Нягтлан бodoх бүртгэлийн суурь**

Компани нягтлан бodoх бүртгэлийн аккурэл суурьд үндэслэн санхүүгийн тайлангаа бэлтгэдэг.

#### **Санхүүгийн тайланг бэлтгэх төсөөлөл**

Компани одоо болон алсын ирээдүйд үйл ажиллагаа тасралтгүй үргэлжлүүлнэ гэсэн төсөөлөлд үндэслэн санхүүгийн тайлангаа бэлтгэдэг.

*Санхүүгийн тайлангийн салигүй хэсэг болно.*

## “ХАРХОРИН” ХК

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон  
жилийн санхүүгийн тайлангийн тодруулга

### 3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО

#### Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгө нь компанийн касс дахь бэлэн мөнгө, төлбөр гүйцэтгэх зориулалттай банк дахь харилцах данснаас бүрдэнэ.

Мөнгө ба түүнтэй адилтгах зүйлсийг нэрлэсэн үнээр бүртгэдэг. Гадаад валютаархи мөнгөн хөрөнгийг Монголбанкнаас зарласан албан ханшаар төгрөгт шилжүүлж бүртгэдэг.

#### Гадаад валютын гүйлгээ

Гадаад валютаар хийгдэг мөнгөн хөрөнгийн зүйлсийн ажил гүйлгээг тухайн өдрийн албан ханшаар төгрөгт хөрвүүлж, төгрөг валютаар давхар бүртгэдэг.

Түүхэн өргөөр тодорхойлогдсон гадаад валютаархи мөнгөн бус зүйлсийг ажил гүйлгээ гарсан өдрийн албан ханшаар төгрөгт хөрвүүлж бүртгэдэг.

Зах зээлийн үнээр илэрхийлэгдсэн гадаад валютаархи мөнгөн бус зүйлсийг түүний өргтийг тодорхойлох үед байсан албан ханшаар төгрөгт хөрвүүлж бүртгэдэг.

Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн зүйлсийн үлдэгдэлд балансын өдрөөр Монголбанкнаас зарласан албан ханшаар ханшийн тэгшитгэл хийж, ханшийн өөрчлөлтийн улмаас гарсан зөрүүг ханшийн тэгшитгэлийн олз гарзаар хүлээн зөвшөөрдөг. Энэ нь ханшийн зөрүүгийн бодит бус олз ба гарз байна.

Валютын солилцоо, арилжааны явцад үүсэн ханшийн зөрүүг валютын арилжааны олз, гарзаар хүлээн зөвшөөрдөг. Энэ нь ханшийн зөрүүгийн бодит олз ба гарз байна.

#### Бусад авлага, урьдчилж төлсөн тооцоо

Байгууллага, иргэдэд буцаан төлөгдөх нөхцөлтэйгээр олгосон мөнгө, худалдан авах бараа, үйлчилгээний үнийн урьдчилгаа, татвар шимтгэлийн авлагыг бусад авлага, урьдчилж төлсөн тооцоонд бүртгэдэг.

Эдгээр авлага, тооцоог нөхөлтийн өртөг буюу төлсөн мөнгөний нэрлэсэн үнээр бүртгэдэг.

#### Бараа материал

Бараа материалыг өртөг зах зээлийн үнийн аль багаар нь санхүүгийн тайланд тусгадаг. Өртөг нь бараа материалыг худпалдан авахтай холбогдоон зардлаас бүрддэг. Бараа материалыг зарлага болгоходо дундаж өргтийн аргыг хэрэглэдэг.

#### Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийг санхүүгийн тайланд анхны өргөөс хуримтлагдсан элэгдэл, хуримтлагдсан үнэ цэнийн бууралтыг хассан цэвэр дүнгээр тайлаганана.

Анхны өртөг нь хөрөнгийг худалдан авсан үнэ дээр түүний олж бэлтгэхэд гарсан зардал, капиталжуулсан засварын зардлыг нэмсэн дүнгээс бүрддэг.

*Санхүүгийн тайлангийн салигүй хэсэг болно.*

## “ХАРХОРИН” ХК

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон  
жилийн санхүүгийн тайлангийн тодруулга

Үндсэн хөрөнгийн үнэ цэнийг тогтмол хянаж, дансны үнэ, балансын өдрөөрхи бодит үнэ цэнийн хооронд материаллаг зөрүү гарсан нөхцөлд дахин үнэлгээ хийнэ.

Үндсэн хөрөнгийн бодит үнэ цэнийг тогтооходоо зах зээлийн өнөөгийн үнэ үнээр тодорхойлно. Мэргэжлийн үнэлгээнид уг үнийг тогтооно.

Дахин үнэлгээний үр дүнд хөрөнгийн үнэ цэнэ нэмэгдэж байвал үнэлгээний нэмэгдлийг өмчөөр хүлээн зөвшөөрдөг. Харин дахин үнэлгээний үр дүнд хөрөнгийн үнэ цэнэ буурч байвал үнэ цэнийн бууралтын алдагдлыг тайлант үеийн зардлаар хүлээн зөвшөөрдөг.

Үндсэн хөрөнгийн элэгдлийг түүнийг ашиглалтанд орсон хугацаанаас эхэлж, хөрөнгийн ашиглагдах хугацааны туршид шулуун шугамын аргаар тооцож байгуулдаг.

Элэгдэл тооцох арга болон хугацаа нь Монгол Улсын “Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай” хуулийн заалтанд нийцэх бөгөөд үндсэн хөрөнгийн элэгдүүлэх хугацаа нь дараах байдалтай байна.

Үндсэн хөрөнгийн төрөл	Ашиглагдах хугацаа /жилээр/
Тавилга эд хогшил	10
Компьютер	3
Тээврийн хэрэгсэл	10
Бусад хөрөнгө	10

Үндсэн хөрөнгөнд хийсэн урсгал болон их засварын зардлыг засвар хийх тухай бүр тооцож, бүртгэнэ.

Засварын зардал нь үндсэн хөрөнгийн анхдагч үнэлгээний үед тогтоосон бүтээмжийг дээшлүүлэхүүц, компанийн хүртэх ирээдүйн эдийн засгийн өгөөжийг нэмэгдүүлэхүүц, ашиглагдах хугацааг уртасгахаар байвал тэдгээрийг капиталжуулах ёстой. Бусад засварын зардлыг урсгал засвар гэх бөгөөд тайлант хугацааны зардлаар хүлээн зөвшөөрнө. Үндсэн хөрөнгийг данснаас хасахдаа үлдэгдэл өртгийн дүнгээр хөрөнгө данснаас хассаны гарзыг, худалдан борлуулах үед хөрөнгийн үлдэгдэл өртөг, худалдсан үнийн зөрүүгээр хөрөнгө худалдан борлуулсны олз, гарзыг хүлээн зөвшөөрдөг.

### Дансны өглөг

Компанийн үндсэн үйл ажиллагаатай холбогдсон зээлээр худалдан авсан бараа, материалын үнэ, хүлээн авсан үйлчилгээний үнэ болон үйл ажиллагааны зардлыг хуримтлуулснаас үүссэн өглөгийг дансны өглөгөөр хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

Дансны өглөгийг худалдан авсан бараа, үйлчилгээний нэрлэсэн үнээр бүртгэдэг.

### Бусад өглөг

Компанийн ажилчиддтай цалин, тэтгэвэр болон бусад тооцоогоор үүссэн өглөг болон бусад аж ахуй нэгж, иргэдтэй үүссэн дансны өглөгөөс бусад өр төлбөрийг бусад өглөгөөр хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

Санхүүгийн тайлангийн салигүй хэсэг болно.

**“ХАРХОРИН” ХК**  
2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон  
жилийн санхүүгийн тайлангийн тодруулга

**Татварын өглөг**

Монгол улсын хуулийн дагуу улс, орон нутгийн төсөв, нийгмийн даатгалын санд төлж байгаа аж ахуй нэгжийн орлогын албан татвар, хувь хүний орлогын албан татвар, өөрөө явагч хэрэгслийн албан татвар болон бусад татвар, хураамжийн өр төлбөрийг татварын өглөг гэж ангилсан.

**Үрт хугацаат өр төлбөр**

Үрт хугацаат өр төлбөрт нэг жилээс дээш хугацаанд төлөх бусад байгууллага, хувь хүнд өгөх өглөгийг бүртгэдэг.

**Эзэмшигчдийн өмч**

Эзэмшигчдийн өмч нь хувьцаа эзэмшигчдээс оруулсан хөрөнгө, хуримтлагдсан ашгаас бүрдэнэ. Эзэмшигчдийн өмчийг түүхэн өртгөөр нь санхүүгийн тайланд илэрхийдэг.

Хувьцаат капитал нь эзэмшигчдээс оруулсан энгийн хувьцааны дунгээр илэрхийлэгдэх бөгөөд нийт дун нь нэгж хувьцааны нэрлэсэн үнийг нийт хувьцааны тоогоор үргүүлсэн дун байна.

Хуримтлагдсан ашиг нь өмнөх ба тайлант жилүүдийн үйл ажиллагааны цэвэр үр дүнг илэрхийлдэг бөгөөд нэрлэсэн дунгээр санхүүгийн тайланд тусгадаг.

**Үйл ажиллагааны зардал**

Компанийн удирдлагын болон борлуулалтын үйл ажиллагаанд хамаарах зардлыг үйл ажиллагааны зардлаар хүлээн зөвшөөрдөг. Үйл ажиллагааны зардлыг тайлант хугацаанд ногдох дунгээр нь Збүртгэдэг.

**Болзошгүй өр төлбөр**

Болзошгүй өр төлбөр нь компанийн өнгөрсөн үйл явдлын үр дүнд гарах боломжтой үүрэг хариуцлага бөгөөд түүний орших байдал нь компанийн бүрэн хяналтанд ороогүй, зөвхөн ирээдүйд нэг буюу хэд хэдэн үйл явдлын тохиолдол, эс тохиолдлоор батлагдах одоогийн үүрэг хариуцлага юм.

Болзошгүй өр төлбөрийг барагдуулахын тулд эдийн засгийн өгөөжийг агуулсан нөөцийг гадагш шилжүүлэх шаардлагатай гэсэн магадлалтай биш, уг үүрэг хариуцлагыг төлөх төлбөрийн дунг найдвартай хэмжих боломжгүй бол балансад хүлээн зөвшөөрдөггүй.

**Компанийн орлогын албан татвар**

Компанийн санхүүгийн жилийн татвар ногдуулах орлого, түүнд ногдуулсан орлогын албан татварыг Монгол Улсын “Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай” хуулийн дагуу тодорхойлж тайлагнадаг.

## **“ХАРХОРИН” ХК**

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон  
жилийн санхүүгийн тайлангийн тодруулга

---

Тус хуулийн дагуу 3.0 тэрбум төгрөг хүртлэх татвар ногдуулах жилийн орлогод 10 хувиар, 3.0 тэрбум төгрөгөөс дээш татвар ногдуулах жилийн орлого олсон бол 300.0 сая төгрөг дээр 3.0 тэрбумаас дээш давсан орлогын дүнгийн 25 хувиар нэмж, орлогын албан татвар ногдуулж төлдөг.

### **Хувь хүний орлогын албан татвар**

Монгол Улсын “Хувь хүний орлогын албан татварын тухай” хуулиар компани ажиллагсадад олгосон цалин, түүнтэй адилтгах орлогоос 10 хувиар хувь хүний орлогын албан татварыг суутгаж, төсөвт төлөх үүрэг хүлээндэг.


### **Нийгмийн даатгалын шимтгэл**

Монгол Улсын “Ниймийн даатгалын тухай” хуулийн дагуу компани нь ажиллагсадад олгосон цалин, түүнтэй адилтгах орлогын дүнгээс даатгуулагчаас 11.5 хувиар, ажил олгогчоос 12.5 хувиар тооцож нийгмийн даатгалын шимтгэлийг төлөх үүрэг хүлээндэг.

### **Нэмэгдсэн өртгийн албан татвар**

Монгол Улсын “Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай” хуулиар нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ), ноогдох бараа үйлчилгээний орлогод 10 хувиар тооцож , НӨАТ төлдөг.

*Санхүүгийн тайлангийн салигүй хэсэг болно.*



## “ХАРХОРИН” ХК

2019 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр дуусгавар  
болсон жилийн санхүүгийн тайлангийн тодруулга  
(төгрөг)

### 4. МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛГАХ ХӨРӨНГӨ

Ангилал	2018.12.31	2019.12.31
Касс дахь бэлэн мөнгө /төгрөг/	188,400.00	631,100.00
Дүн	188,400.00	631,100.00
Банкин дахь харилцах	1,708,400.00	750,900.00
Дүн	1,708,400.00	750,900.00
<b>Нийт мөнгөн хөрөнгийн дүн</b>	<b>1,896,800.00</b>	<b>1,382,000.00</b>

### 5. ДАНСНЫ АВЛАГА

Ангилал	2018.12.31	2019.12.31
Дансны авлага	903,269,300.00	540,691,800.00
Дүн	903,269,300.00	540,691,800.00

### 6. БУСАД АВЛАГА

Ангилал	2018.12.31	2019.12.31
Бусад авлага	268,650,000.00	54,439,100.00
Дүн	268,650,000.00	54,439,100.00

### 7. БУСАД САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ

Ангилал	2018.12.31	2019.12.31
Хөрөнгө оруулалт	1,296,917,500.00	1,296,917,500.00
Дүн	1,296,917,500.00	1,296,917,500.00

Санхүүгийн тайлангийн салигүй хэсэг болно.

12

**“ХАРХОРИН” ХК**

2019 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр дуусгавар  
болсон жилийн санхүүгийн тайлангийн тодруулга  
(төгрөг)

**8. БАРАА МАТЕРИАЛ**

Ангилал	2018.12.31	2019.12.31
Бэлэн бүтээгдэхүүн	123,876,400.00	55,363,000.00
Бараа	6,881,600.00	5,736,900.00
Хангамжийн материал	222,755,500.00	262,318,400.00
Бусад	71,980,000.00	68,250,000.00
<b>Дүн</b>	<b>425,493,500.00</b>	<b>391,668,300.00</b>

**9. БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ**

Ангилал	2018.12.31	2019.12.31
Бусад эргэлтийн хөрөнгө	2,095,101,800.00	2,636,360,000.00
<b>Дүн</b>	<b>2,095,101,800.00</b>	<b>2,636,360,000.00</b>

*Санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.*

“ХАРХОРИН” ХК  
2019 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр дуусгавар  
болсон жилийн санхүүгийн тайлангийн тодруулга  
(төгрөг)

10. ҮНДСЭН ХӨРӨНГӨ

Хөрөнгийн ангилал	Барилга байгууламж	Тавилга эд хогшил	Машин тоног төхөөрөмж	Тээврийн хэрэгсэл	Комьютер дагдаах хэрэгсэл	Нийт
а. Аянхны ортог						
Эхний Үлдэгдэл	836,493,300.00	163,291,400.00	293,187,700.00	742,130,700.00	16,993,100.00	2,052,096,200.00
Нэмэгдсэн	53,400,000.00	6,200,000.00	5,700,000.00	200,000,000.00	-	265,300,000.00
Хасадсан	-	-	-	-	-	-
Эцсийн Үлдэгдэл	889,893,300.00	169,491,400.00	298,887,700.00	942,130,700.00	16,993,100.00	2,317,396,200.0
б. Хурымтлагдсан элэгдэл						
Эхний Үлдэгдэл	493,333,300.00	24,739,400.00	144,123,100.00	179,762,600.00	6,294,000.00	404,252,400.00
Нэмэгдсэн	4,194,100.00	-	15,270,800.00	-	1,762,900.00	21,227,800.00
Хасадсан	-	-	-	-	-	-
Эцсийн Үлдэгдэл	53,527,400.00	24,739,400.00	159,393,900.00	179,762,600.00	8,056,900.00	425,480,200.00
в. Үлдэгдэл өргөг						
Эхний Үлдэгдэл	787,160,000.00	138,552,000.00	149,064,600.00	562,368,100.00	10,699,100.00	1,647,843,800.00
Эцсийн Үлдэгдэл	836,365,900.00	144,752,000.00	139,493,800.00	762,368,100.00	8,936,200.00	1,891,916,000.00

Санхүүгийн тайллангийн салижүй хэсэг ботоо.

“ХАРХОРИН” ХК

2019 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр дуусгавар  
болсон жилийн санхүүгийн тайлангийн тодруулга  
(төгрөг)

11. БИЛОГИЙН ХӨРӨНГӨ

Хөрөнгийн ангилал	Тоо	2018.12.31	Тоо	2019.12.31
Мод	259,955	1,082,788,300.00	259,955	1,082,788,300.00
<b>Дүн</b>	<b>259,955</b>	<b>1,082,788,300.00</b>	<b>259,955</b>	<b>1,082,788,300.00</b>

12. БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР

Ангилал	2018.12.31	2019.12.31
Дансны өглөг	6,089,839,400.00	6,718,914,200.00
Цалингийн өглөг	92,906,400.00	135,241,900.00
НДШ-ийн өглөг	11,717,800.00	18,233,400.00
ХХОАТ-ын өглөг	11,558,000.00	9,777,300.00
Бусад татварын өр	-	12,628,000.00
Богино хугацаат зээл	1,015,753,100.00	1,088,046,800.00
Хүүний өглөг	380,036,000.00	543,576,800.00
<b>Дүн</b>	<b>7,601,810,700.00</b>	<b>8,526,418,400.00</b>

13. УРТ ХУГАЦААТ ЗЭЭЛ

Ангилал	2018.12.31	2019.12.31
Урт хугацаат зээл	673,379,900.00	70,000,000.00
<b>Дүн</b>	<b>673,379,900.00</b>	<b>70,000,000.00</b>

Санхүүгийн тайлангийн салигүй хэсэг болно.

“ХАРХОРИН” ХК



УЛИАСТАЙ ВАН  
АУДИТ ХХК

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

2019 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр дуусгавар  
болсон

Санхүүгийн тайлангийн аудит

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл  
дараах хаягаар харилцана уу:

Захирал:  
П.Ганцолмон  
Утас: 7600 7405, 9609 7405

Аудитор  
Д.Нарантуяа  
Утас : 7600-7405

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

**Асуудал 1:** Орлогын тайлан, Е-баримтын орлогын зөрүүгийн талаар

**Асуудал 2:** ХХОАТ-ын хөнгөлөлтийн зерүүгийн талаар

“УЛИАСТАЙ ВАН АУДИТ” ХХК

Хэвлэсэн огноо :  
2020 оны 03-р сарын 20

### Менежментийн захидал

Аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг компанийн удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитийн олон улсын стандарт /АОУС/-ын дагуу хийгддэг аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гарахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан “Хархорин” ХК-ийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**Асуудал 1:** Орлогын тайлан, Е-баримтын  
орлогын зөрүүгийн талаар

Ажиглалт

Тус байгууллагын Орлогын дэлгэрэнгүй тайлангийн үндсэн үйл ажиллагааны борлуулалтын орлогын дүнг е-баримтаар шивсэн орлоготой тулган шалгахад дараах зөрчил илэрсэн болно. Үүнд:

Орлогын дэлгэрэнгүй тайлан дээр тусгагдсан үндсэн үйл ажиллагааны борлуулалтын орлогын дүн 887,637,700.00 төгрөг харин е-баримтаар шивсэн орлого 130,269,012.30 төгрөг буюу 757,368,687.70 дутуу тайлагнасан байна.


Зөвлөмж

Үндсэн үйл ажиллагаанаас орсон орлогоо заавал ебаримтад орлогоо тайлагнасан байна. Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл, Татвар ногдуулалт төлөлт

*28.5. Татвар төлөгч борлуулалт хийх тухай бурд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий толборийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахинаар илгээх уүрэгтэй.*

Эрсдэлүүд

Орлогын дүнг ебаримтанд дутуу шивсэний улмаас татварын шалгалтаар акт, торгууль, нөхөн төлбөрт орох эрсдэлтэй.



**Асуудал 2: ХХОАТ-ын хөнгөлөлтийн зорүүгийн талаар**

**Ажиглалт**

Цалин хөлстэй холбоотой Сүүтганы тайланда тусгагдсан хөнгөлөлтийн дунг, тухайн байгууллагын НД-ийн тайлангаар тайлагнагдсан Цалингийн хүснэгтийн нэгтгэлтэй тулган шалгаж улмаар хөнгөлөлтийн тооцооллыг хийж үзэхэд Аудиторын шалгах хүснэгт дахь Цалингийн нэгтгэл хүснэгтээр тухайн байгууллагын хөнгөлөлтийг Алтанбагана, Ганбат, Урамнчимэг гэх мэт хүмүүст татварын хөнгөлөлтийг илүү тооцож, харин татварын хөнгөлөлтийг нийт нэр бүхий 40 хүнд дутуу тооцож цалинг олгосон.

2019 онд мөрдөгдөж байсан Хувь хүний орлогын албан тухай хуулийн

17дугаар зүйл. Цалин хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлох

17.1. Цалин хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах орлогод албан татвар ногдуулах орлогыг дараах байдлаар тодорхойлоно:

17.1.1. Энэ хуулийн 11.1.1, 11.1.6-д заасан орлогоос нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд төлсөн шимтгэлийг хассан дүнгээр;

17.1.2. Энэ хуулийн 11.1.2-11.1.5-д заасан орлогын тухайд нийлбэр дүнгээр нь.

**Зөвлөмж**

Хувь хүний орлогын албан тухай хуулийн

24 дүгээр зүйл. Албан татварын хөнгөлөлт чөлөөлөлт үзүүлэх

24.1. Энэ хуулийн 11.1.1-11.1.6-д заасан орлогод ногдох жилийн албан татварт дараах хэмжэээр албан татварын хөнгөлөлт үзүүлнэ.

Д/О	Албан татвар ногдуулах жилийн орлогын хэмжээ /төгрөгөөр/	Албан татварын хөнгөлөлтийн хэмжээ /төгрөгөөр/	
		2018 он	2019 он ба түүнээс хойш
1	0-6 000 000 хүртэл	160 000	240 000
2	6 000 000-12 000 000 хүртэл	140 000	220 000
3	12 000 000-18 000 000 хүртэл	120 000	200 000
4	18 000 000-24 000 000 хүртэл	100 000	180 000
5	24 000 000-30 000 000 хүртэл	80 000	160 000
6	30 000 000-36 000 000 хүртэл	60 000	140 000
7	36 000 000 ба түүнээс дээш	-	-

**Эрсдэлүүд**

Ажилтан албан хаагчдын цалингаас хуульд заасан ХХОАТ-ын хөнгөлөлтийг илүү эсвэл дутуу сүүтгах нь цалин хөлстэй холбоотой данснуудын дүнгүүд буруу илэрхийлэгдэж улмаар санхүүгийн тайлан алдаатай гарах эрсдэлтэй.